

МХБ ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн
А/111 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх газар, алба	Хүрэх түвшин, үр дүн
Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх						
1.1.	1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн хэвлэлийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, youtube суваг/, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх,		-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	2024.03.20- 2024.12.01	БХГ- МОНХА, ЭБАТ	Зах зээлийн оролцогч нарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах, хууль тогтоомжийг танин мэдэх боломжоор хангасан.
1.2.	1.2. Үнэт цаасны өдөрлөг зохион байгуулах		Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар нотломжийг хавсаргах	3 дугаар улиралд	Бүх газар алба	Хөрөнгийн зах зээлийг сурталчлах, ойлголт мэдээлэл түгээх
1.3.	1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны тайлангийн ар хуудаст "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн утас байршуулах		Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй уриалгыг самбарт байршуулан олон нийтэд мэдээлэл түгээх нотломжийг хавсаргах	Тухай бүр	БХГ- МОНХА, ЭБАТ	Байгууллагын ажилтан болон үйлчлүүлж байгаа олон нийтэд авлигын эсрэг уриалгыг хүргэсэн.
	1.3.1. Байгууллагаас зохион байгуулдаг үнэт цаасны мэдлэг олгох анхан шатны сургалтын гарын авлагын ар талын хуудаст 110 гэх				ҮАГ-АА, ЭБАТ	

	мэдээллийн утас байршуулах				
1.4.	1.4. Үнэт цаасны видео контент хийх	Хөрөнгийн зах зээлд оролцогчдын хүрээнд авлигын мэдээлэх 110 утсыг сурталчлах нотломжийг хавсаргах	Эхний контентыг 2 дугаар улиралд Дараагийн контентыг 3 дугаар улиралд	БХГ-МОНХА, ЗСГ-СА, ЭБАТ	Нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгийн зах зээлийг түргэн шуурхай олон нийтэд түгээх
<i>Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх</i>					
2.1.	2.1. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны сургалтад эрх бүхий албан тушаалтнуудад хамруулсан байх,	Сургалтад хамруулсан нотломжийг хавсаргах	3 дугаар улиралд	ЗСГ-ЗА, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, ЭБАТ	Байгууллагын эрх бүхий ажилтнууд авлигын эсрэг ойлголт, мэдлэг авсан байх
2.2.	2.2. Ажилтныг сонгон шалгаруулалтгүйгээр томилохгүй байх	-Дүрэм журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулах -Нийт сонгон шалгаруулалтад хэдэн ажлын байранд зарлагдсан хамрагдсан хүний тоог хүний нөөцөөс авах	Тухай бүр	ЗСГ-ЗА, ЭБАТ	Нээлттэй ил тод байх шударга байх, зарчмыг баримтлах
	2.2.1. Байгууллагын ажилтнуудын ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэхэд ERP системийг ашиглах боломжийг судлах, ёс зүй, зан үйлийг үнэлэх сэтгэл зүйн туршилтыг өргөжүүлэх талаар судлах	- ERP нэвтрүүлж гүйцэтгэлийн үр дүн сайжруулах	Улирал тутам	ЗСГ-ЗА, ЭБАТ	Ажлын байр бүрээр ажлын гүйцэтгэл дүгнэх үзүүлэлтийг боловсруулах, мөрдүүлэх
2.3.	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх	- Шилэн дансыг тогтмол хөтөлдөг, Тайланд мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр тусгаж, мэдээллийн агуулга сайжирсан байх	Тухай бүр	ЗСГ-СА, ЭБАТ	Төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн зарцуулалтыг нээлттэй тогтмол мэдээллэх
	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого,	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,	Тухай бүр	ЗСГ-СА, ХА, ЭБАТ	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухай бүр мэдээлэх, хэргэжилтийг хангах

2.4.	зохицуулалтын газарт хүргүүлж зөвшөөрөл авсан байх	үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, гүйцэтгэл үр дүнг хариуцан ажиллах /цахим системээр/			
2.5.	Байгууллагын цахим хуудсанд санал гомдол авах цэсийг идэвхжүүлэх	Үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол мэдээллийн судалгааг тогтмол гаргах	Тухай бүр	БХГ-МОНХА, ЗСГ-ЗА, ҮАГ-МТА, ЭБАТ, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Хүнд суртал чирэгдэл багасах
<i>Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах</i>					
3.1.	3.1. Байгууллагын албан ёсны цахим хуудас дээр авлигын эрсдэл ба авлига гаргах, авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн контентуудыг байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах,	Мэдээллийг түгээж олон нийтээс хандалт авах	Тухай бүр	БХГ-МОНХА, ЭБАТ	Цахим сүлжээгээр дамжуулан авлигын эсрэг ойлголтой болох
3.2.	3.2.1. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, 3.2.2. Сангийн яамнаас ирүүлсэн зөвлөмж 3.2.3. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад мэргэжлийн газрууд, дээд газруудаас өгсөн зөвлөмж	Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	Тухай бүр	ЗСГ-ЗА, Бүх газар, алба	Байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байх нөхцлийг бүрдүүлэх
	3.2.4. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шат дараалсан хяналтыг хэрэгжүүлэх	Байгууллагаас гарч буй гэрээ, хэлцлийг шат дараатай хянуулан хяналтыг хэрэгжүүлэн цахим хаягт байршуулан ажиллах	Тухай бүр	ЗА-ХА, ЭБАТ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах

	3.2.5. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх Үүнд: үйлчилгээгээ цахимжуулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, мэдээллийн хэлбэр, давтамж сайжирсан байх	Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй хууль дүрэм журмыг мэдээллийн цахим хаягт байршуулснаар мэдээллийн ил тод байдалд хүрэх зохион байгуулсан байх.	Тухай бүр	Бүх газар, алба	Байгууллагад мөрдөгдөж байгаа дүрэм журмыг тогтмол шинэчлэн цахим хаягт байршуулах
3.3.	Байгууллагын албан ёсны цахим хуудас болох www.mse.mn цахим хуудаст "ИЛ ТОД БАЙДАЛ" гэсэн цэсэд байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангах	Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх. /Цахим хуудас дээр мэдээллийг байршуулсан байх	Тухай бүр	ЗА-ХА, ЭБАТ, БХГ-МОНХА, УАГ-МТА	Олон нийтэд төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, бусад гэсэн мэдээллийг мэдээлэх
3.3.1.	Авлигатай тэмцэх газраас 2 удаагийн сургалтыг биржид бүртгэлтэй хк болон гишүүн компаниудад авлигаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохиох	Нотломжийг хавсаргах	2,3 дугаар улиралд	ЗА-ХА, ЭБАТ, ХЗГ-БА, ХША	Хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах
3.3.2.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг тогтмол байршуулах	Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх	Тухай бүр	Бүх газар, алба	Мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулснаар олон нийтэд мэдээллийг хугацаа алдахгүй цаг тухай бүр хүргэх

Жич: Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг тухайн төрийн байгууллага хариуцах ба төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай захиран зарцуулж ажиллах нь зүйтэй.